



2.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиудад заасан болон компанийн дүрэмд заасан дараах эрхтэй.

- 1/ Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 2/ ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
 - 3/ Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
 - 4/ Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ хангана.
1. Хувь нийлүүлэгчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:
- 1/ Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
 - 2/ Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
 - 3/ Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
2. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно. ТУЗ-өөс тогтоосон үнэ нь үнэлгээний байгууллагын дүгнэлтэд заасан үнээс доогуур байж болохгүй.





2.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

3. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч болон эзэмшигчид нь жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэх эрхтэй.
4. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрэмд заасан эрхээ эдлэх баталгаа болно.
5. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 болон 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.
6. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцааг эзэмшигчид нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.
7. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
8. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
9. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно.

